

**“ГЮУДОНХАУС” ХХК-НИЙ НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН  
6-Р ХОРООНЫ НУТАГ, ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН  
ЦОГЦОЛБОР ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
БААЗ” ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН  
ТАЙЛАН**



**Улаанбаатар хот  
2022 он**

**“ГЮУДОНХАУС” ХХК-НИЙ НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6-Р  
ХОРООНЫ НУТАГ, ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОР  
ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗ” ТӨСЛИЙН  
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5659582**

**ХЯНАСАН:**

ГОРХИ ТЭРЭЛЖИЙН БЦГ-Н

ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН:

Ө.УЯНГА

**ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:**

“ГЮУДОНХАУС” ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

З.СЭЛЭНГЭ

“ГЮУДОНХАУС” ХХК-НИЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ

АЖИЛТАН:

Б.ТҮВШИНЖАРГАЛ

Улаанбаатар хот

2022 он

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

### ОРШИЛ

1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ДҮГНЭЛТ

## ОРШИЛ

Манай компани нь 2012 онд анх байгуулагдсан бөгөөд худалдааны зуучлал, гадаад худалдаа, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн болно.

Налайх дүүргийн нутаг дэвсгэрт орших Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Чингис уулын баруун талд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаагаа явууж байна. Уг талбайд МУ-ын аялал жуулчлалын салбарын дээд зэргийн стандарт шаардлагыг хангасан чанартай үйлчилгээ бүхий гадаад, дотоодын аялагч, амрагчдын амрах тав тухтай орчныг бүрдүүлсэн аялал жуулчлалын баазыг нийслэл хотод ойролцоо байрлал бүхий Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын үзэсгэлэнт байгалийн нөхцөлд түшиглэн ажиллаж байна. Бид төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг, байгаль орчны үнэлгээ зөвлөгөөний мэргэжлийн байгуулга “Эм И Си Эс Зэт Би” ХХК-тай хамтран 2017 онд тайланг хийж гүйцэтгэн БОАЖЯ-р батлуулсан болно.

Байгаль орчны талаархи үйл ажиллагааг цаг үргэлж сайжруулж байхын тулд бид дараах үүрэг хүлээж, хэрэгжилтийг ханган ажиллах. Үүнд:

- Байгаль орчны удирдлагын ISO 14001 стандартад нийцсэн байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн үйл ажиллагааны байнгын хяналт, ахиц дэвшлийг хангах;
- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учирах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээ авах;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулах;
- Компанийн удирдлагууд, орон нутгийн иргэд болон хорооны удирдлагатай байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, эргэх холбоо бүхий ажил хэрэгч харилцааг буй болгох;
- Бид өөрийн үйл ажиллагаа болоод төслийн цар хүрээ, нөхцөл байдал хоорондын бодит уялдаа холбоог хангах үүднээс үйл ажиллагааны тогтолцоонд тодорхой хугацаанд хяналт тавих.

2022 онд БОАЖЯ-р батлуулсан БОМТ-ний болон бусад нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудаа тайлагнав.

## 1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Төслийн нэр:** Аялал жуулчлалын бааз

**Төслийн дугаар:** Б/84

**Төслийн зорилго:**

Уг төсөл хэрэгжснээр нийслэлд хамгийн ойр байгалийн үзэсгэлэнд газарт аялал, амралтын зорилгоор ажиллах газрын тоо нэмэгдэн, жуулчид болон иргэдийг аятай, тухтай амрах боломжийг нэмэгдүүлэх юм. Цаашид баазын хүчин чадлын 30 хувийг байгальд ээлтэй аргачлалаар (ЭКО) аргачлалаар 4 улирлын ажиллагаанд оруулж, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарч ажиллана. Мөн түүнчлэн төсөлд дараах зорилгуудыг тавин ажиллаж байна.

- ❖ УБ хотын болон гадаадын жуулчдын аялж амрах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах
- ❖ Үзэсгэлэнт байгалийг түшиглэн тохь тухтай, соёлтой үйлчилгээ бүхий өндөр зэрэглэлийн амралтын газар байгуулах
- ❖ Байгалийн сайханд түшиглэсэн ногоон хөгжил хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн байгалийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр иргэдийн орлогыг тогтвортойгоор дээшлүүлэн ногоон худалдан авалтыг хийхэд оршино.
- ❖ Ажлын байр бий болгох

### Үйл ажиллагааны чиглэл:

Дээрх зорилтуудыг шат дараалалтайгаар хэрэгжүүлэхдээ Аялал жуулчлалын бааз нь дараах үйл ажиллагааны чиглэлийг баримтлах юм.

Үйлчилгээний процесс:

Үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж

- Зоогийн газар, ресторан /Цэсийн болон захиалгын хоолны үйлчилгээ/
- Кофе шоп
- Амрагч, жуулчдыг тохь тухтай байраар хангах / Нийтийн амрагчийн байр, Гэр бүлээр амрах сингли байшин /
- Саравч, сүүдрэвч
- Шүршүүр, бие засах газар
- Угаалгын газар
- Угтах байр
- Явган зам
- Авто зогсоол, гараж
- Сагсан болон гар бөмбөгийн талбай
- Хүүхдийн тоглоомын талбай
- Бусад үйлчилгээ /Түүх соёлын дурсгалт газрын танилцуулга, маршрутын аялал г.м/

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: " Гюудонхаус" ХХК.

Улсын бүртгэлийн дугаар: 9011380138

Регистрийн дугаар: 5659582

Хаяг: Улаанбаатар хот Баянгол дүүрэг 18-р хороо  
4-р хороолол жалханц хутагт дамдинбазар, 65,  
31 тоот.

Утас: 94000007

## ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ

| Зураг   | Агуулга  | Утга   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
|---|--|--|---------|--------|---|-------------------|------------------|---|-------------------|------------------|---|-------------------|------------------|---|-------------------|------------------|--|
|  | <b>Байршил:</b>  | Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6-р хороо, Чингис уулын баруун тал гэх газар |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
|   | <b>БОННУ огноо:</b>  | 2017 онд “Эм И Си Эс Зэт Би” ХХК   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
|   | <b>Ажил эхэлсэн огноо:</b>   | 2017 онд   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
|   | <b>Ажил дууссан огноо:</b>   | Одоог хүртэл хэрэгжиж байна.   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
|   | <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Өргөрөг</th> <th>Уртраг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>107° 23' 44.011"E</td> <td>47° 49' 47.283"N</td> </tr> <tr> <td>2</td> <td>107° 23' 36.386"E</td> <td>47° 49' 50.505"N</td> </tr> <tr> <td>3</td> <td>107° 23' 41.760"E</td> <td>47° 49' 56.374"N</td> </tr> <tr> <td>4</td> <td>107° 23' 49.479"E</td> <td>47° 49' 53.012"N</td> </tr> </tbody> </table> | №  | Өргөрөг | Уртраг | 1 | 107° 23' 44.011"E | 47° 49' 47.283"N | 2 | 107° 23' 36.386"E | 47° 49' 50.505"N | 3 | 107° 23' 41.760"E | 47° 49' 56.374"N | 4 | 107° 23' 49.479"E | 47° 49' 53.012"N |  |
| №   | Өргөрөг  | Уртраг   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
| 1   | 107° 23' 44.011"E  | 47° 49' 47.283"N   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
| 2   | 107° 23' 36.386"E  | 47° 49' 50.505"N   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
| 3   | 107° 23' 41.760"E  | 47° 49' 56.374"N   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |
| 4   | 107° 23' 49.479"E  | 47° 49' 53.012"N   |         |        |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |   |                   |                  |  |

Уг төсөл нь Улаанбаатар хот Налайх дүүрэг, 6-р хороо, Чингис уулын баруун тал гэх нэртэй газарт байрлана.



Зураг.2. Төсөл хэрэгжиж буй талбай

## ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ


Аялал жуулчлалын бааз нь нэг ээлжиндээ 30-60 хүнийг зэрэг хүлээн авах хүчин чадалтай 3-4 ор бүхий 4-н ханатай 10 гэр, 5-н ханатай гэр 10, 8 ханатай гэр 2, 2 давхар зоогийн газар, 50-н хүний суудалтай гэр ресторан, 20 хүний суудалтай баар, эр 3, эм 3, нийт 6-н бие засах газар, бохир усны цооног, халуун усны шүүлтүүр 6 ширхэг, автомашины зогсоол, эрчим хүчний холболтын шугам зэргээс бүрдэнэ. Мөн гэр бүлийн амрагчдыг хүлээн авах өндөр зэрэглэлийн вип байр 8-10 ш байх юм.

Баазын гадна орчны тохижилт нь баазын дизай нь орчны байдалтай нийцэл бүхий байгалийн байдлыг илүү тодотгосон байна.

## “Аялал жуулчлалын бааз” төслийн төлөвлөлт

Архитектур төлөвлөлтийн даалгаврийн 8000 м<sup>2</sup> талбайд төлөвлөлт хийх шаардлагыг үндэслэн 1800 м<sup>2</sup> талбайд барилга төлөвлөсөн.


Үүнд: Амрагч, жуулчдыг 4 улирал хүлээн авах зориулалттай дотроо 9 өрөөтэй байшин, 35 м<sup>2</sup> талбайтай 15 жижиг байшин, 4 өрөөтэй 4 байшин төлөвлөж өгсөн. Мөн дотроо халаалтай 15 гэр, халаалтгүй 15 гэр тус тус байрлаж байна.



Зураг 1. Төслийн төлөвлөлтийн зураг



Зураг 1. Рестораны харагдах байдал



Зураг 2. Үйлчлэгч хүлээн авах хэсэг





Зураг 3. Рестораны доторх хэсэг



Зураг 4. Бүрэн халаалттай байшин



Зураг 5. Амрагчийн байрны доторх харагдах байдал



Зураг 6. Амрагчийн байрны ариун цэврийн өрөө болон үүдний хэсэг



Зураг 7. Халаалтгүй зуны гэр



Зураг 8. Халаалттай гэрүүд



Зураг 9. Тоглоомын талбай



Зураг 10. Бильярд, теннис тоглох байшин

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн биелэлтийн тайлан хийхдээ 2017 онд батлагдсан төслийн БОННУ-ний тайлан, 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан хийж гүйцэтгэлээ.

### 2.1. Усан орчны бохирдлыг бууруулах үйл ажилагаа

БОМТ-д тусгагдсан ажил:

| №               | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ  | Хамрах хүрээ          | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт зардал               | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт |
|-----------------|---|-----------------------|-------------|------------|---------------------------|--------------------|----------------------------------|
| 1               | Зуны улиралд эрчимтэй орсон аадар борооны үед үер болох нөхцөлтэй тул амралтын газрын бохир усны цооног усанд автаж болзошгүй тул үерийн үед авч хэрэгжүүлэх яаралтай арга хэмжээг төлөвлөх, Байгалийн гэнэтийн эрсдэлийг урьдчилан тооцох, учирсан тохиолдолд яаралтай авах арга хэмжээний хөтөлбөр боловсруулах | Аялал жуулчлалын бааз | ш           | 1          | Аялал жуулчлалын зардлаас | Гүйцэтгэл          |                                  |
| <b>Нийт дүн</b> |   |                       |             |            | -                         |                    |                                  |

Биелэлт:

- Манай компани нь ашиглаж буй 1 гүний худаг байгаа бөгөөд энэхүү худагт эрүүл ауйн дэглэмийн бүс байгуулан гүний усыг бохирдуулах эх үүсвэр үүсгэхгүй байх талаас анхааран ажиллаж байна.
- Төслийн үйл ажиллагаанаас гарч буй бохир усыг цэвэршүүлэх үүднээс энэ нийт 10 гаруй сая төгрөгөөр бохир ус цэвэршүүлэх системийг суурилуулсан болно. Тус систем нь 3 хэсэг бүхий тунгаах хэсэгтэй бөгөөд байгаль хаяж болох усны стандартын дагуу цэвэршүүлнэ. Энэхүү үйл ажиллагаа маань БОМТ-ны гол зорилт байсан бөгөөд 2022 онд бүрэн суурилуулж ажиллагаандаа оруулсан болно.



Зураг.12. Бохир ус цэвэршүүлэх байгууламжийн цооногийн зураг

3. Хэдийгээр цэвэршүүлэх систем суурилуулсан байгаа боловч энэ нь шууд байгальд хаях боломжгүй учир бохир усыг зөөвөрлүүлэн зайлуулах юм. Тусгай зөвшөөрлийг. /хавсаргав./
4. Мөн 2022 оны 4-р сард НБОГ-р ус ашиглах дүгнэлтээ гаргуулан ажиллаж байна. Энэхүү дүгнэлтийн хүрээнд Налайх дүүрэгтэй ус ашиглах гэрээгээ хийсэн болно.
5. 2022 оны бохир усны дүгнэлтээ Туул голын сав газрын захиргаагаар гаргуулсан болно.

## 2.2. Агаар орчны бохирдлыг бууруулах

БОМТ-д тусгагдсан ажил:

| №                                       | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ   | Хамрах хүрээ                   | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ     | Нийт зардал | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|--|--------------------------------|-------------|------------|---------------------|-------------|--------------------|----------------------------------|
| <b>Агаарын бохирдлыг бууруулах ажил</b> |  |                                |             |            |                     |             |                    |                                  |
| 1                                       | Техникийн шаардлага хангах бүрэн техник, тоног төхөөрөмж сонгох, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгана.   | Аялал жуулчлалын талбай орчинд | ш           | 1          | Дотоод төлөвлөлтөөр | -           | -                  | Агаарын чанарын стандарт         |
|   | Ажиллагсдын агаарын чанарын стандарт, тоосжилтоос урьдчилан сэргийлэх хөдөлмөр хамгааллын хэрэгсэл ашиглах дүрэм, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавих, зааварчилгаа өгөх, сургалт явуулах, |                                | ш           | 1          |                     |             |                    |                                  |

|  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|
| ажиллах орчин үнэр ихтэй, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй орчин тул хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэй байх |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|

**Биелэлт:**

1. Төслийн үйл ажиллагаанд ашиглаж байсан уурын зуухыг 2022 онд бүрэн цахилгаан халалтаар солисон болно. Ийнхүү ажлын үр дүнд агаарын хорт утаа болон үнс зэрэг олон бохирдлыг бууруулсан болно.
2. Амралтын газрын үйл ажиллагаанд ашиглаж буй машин техникийг цаг хугацаанд нь үзлэг оношлогоонд оруулж, техник үйлчилгээг байнга хийж байна.



Зураг.13. Цахилгаан халалтын зуухны зураг

**2.3. Хөрсний бохирдлоос хамгаалах ажил**

БОМТ-д тусгагдсан ажил:

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ  | Хамрах хүрээ   | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ             | Нийт зардал | Биелэлтийн шалгуур                    | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|----------------|-------------|------------|-----------------------------|-------------|---------------------------------------|----------------------------------|
| 1 | Төслийн талбайд шаардлагатай техник тоног төхөөрөмж, материалыг хүргэхэд олон салаа зам гаргахгүйгээр, зам чиглэл | Төслийн талбай | -           | -          | Дотоод зохион байгуулалтаар |             | хатуу хог хаягдлын тархалт үгүй болох |                                  |



|   |  |   |   |  |  |  |
|---|--|---|---|--|--|--|
|   | заасан тэмдэг, зарлал байршуулах   |   |   |  |  |  |
| 2 | Техникийн тос, шатахууны асгаралт гарсан тохиолдолд байгаль орчин, аюулгүй ажиллагааны ажилтнууд асгаралтыг таслан зогсоох, асгарсан тосыг шингээж авах, цаашилбал бохирдсон хөрсийг саармагжуулах буюу хоргүйжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх асгаралтын хариу үйлдэл хийх төлөвлөгөө боловсруулах | - | - |  |  |  |
| 3 | Хөрс хуулалтын стандартын дагуу хуулах технологийг машин механизмын жолооч нарт эзэмшүүлэх мэдээлэл, сургалт зохион байгуулах  |   |   |  |  |  |
| 4 | Хөрс хамгийн ихээр бохирдож болзошгүй газруудад тогтмол хүнд металлын шинжилгээ хийлгэж стандартын хэмжээнд байлгах  |   |   |  |  |  |
| 5 | Ухсан нүх, цооногийг тухай бүрт нь булж тэгшилж байх   |   |   |  |  |  |

Биелэлт:

1. Манай амралтын газар нь засмал замын дэргэд байрлах бөгөөд замаас зассан шороон замаар 100 м яваад орно. Олон зам салаалахгүй юм.
2. Амрагчдын машиныг тусдаа зогсоол үүсгэн, зогсоолыг талбайг бүрэн хайргаар хучиж тос асгаралтаас сэргийлэн ажиллаж байна.
3. Шинээр хөрс хуулах бүтээн байгуулалт хийгдээгүй болно.
4. Ухсан нүх, цооногийг тухай бүрт нь булж тэгшилж байна.



Зураг.14. Замаас салаад орох хэсгийн зураг



Зураг.15. Авто зогсоолын хэсэг

### 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОМТ-д тусгагдсан ажил:

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ    | Хамрах хүрээ                     | Хэмжих нэгж    | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ | Нийт зардал | Биелэлтийн шалгуур | Баримтлах хууль, журам, стандарт              |
|---|---|----------------------------------|----------------|------------|-----------------|-------------|--------------------|---|
| 1 | Мод тарих                               | Аялал жуулчлалын төслийн талбайд | ш              | 20         | 20,000          | 400,000     | Модны ургалт       | Мод тарих хялбаршуулсан аргачлал, БОАЖЯ, 2012 |
| 2 | Ногоон байгууламжийн талбай нэмэгдүүлэх |                                  | м <sup>2</sup> | 500        | 5000            | 2 500 000   |                    |   |

Биелэлт:

Тоос шороог бууруулах болон орчны тохижилтыг сайжруулах зорилгоор жил бүр 20-50 мод тарьж ногоон зүлэг, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх ажлуудыг хийж байна.



Зураг.16. Ногоон байгууламжын зурагнууд



Зураг.17. Ногоон байгууламжын зурагнууд

#### 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОМТ-д тусгагдсан ажил:


| #                               | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ  | Хамрах хүрээ      | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ мян.төг | Нийт зардал мян.төг |
|---------------------------------|---|-------------------|-------------|------------|-------------------------|---------------------|
| 1                               | Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах   | Бүх ажилчдад      | удаа        | 1          | 100.0                   | 100.0               |
| 2                               | Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд 1 удаа зохион байгуулах, дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай хариуцан холбоотой ажиллах | Бүх ажилчдад      | удаа        | 1          | 200.0                   | 200.0               |
| 3                               | Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах             | Төслийг бүхэлд нь |             |            | 150.0                   | 150.0               |
| <b>БОМТ-ний зардал, мян.төг</b> |   |                   |             |            | <b>450.0</b>            |                     |

Биелэлт:

Манай компанийн зүгээс дээрх төлөвлөгөөний хүрээнд дараахь ажлуудыг зохион байгуулсан юм.

Үүнд:

- Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27-р зүйл 27.1,2 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16-р зүйлд заасны дагуу гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж бүх ажилчдыг хамруулан бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
- Түүхий эдийн агуулах, ажилчдын байр зэрэг объектуудын орчинд гал унтраагчдыг шинээр хийж байрлуулан шаардлагатай багажуудыг будаж байрлуулан, гал унтраагуурын тоог нэмэгдүүлж, шаардлагатай багажуудыг нэгтгэн байрлууллаа.
- Ажилчдын байрны гарах хаалганы хананд авралтын схем зургийг хийж байрлуулж, шаардлагатай санамж, тэмдэг тэмдэглэгээг шинээр хийв.
- Ажилчдын байр, оффист **EXIT** тэмдэгийг гарах хаалга бүрт, аваарын гэрлийг 4 ш-ийг тус бүр байрлуулсан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ.



Зураг.18. Галын аюулгүй байдлын булан

## 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОМТ-д тусгагдсан ажил:

| Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ                                     | Хамрах хүрээ     | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ | Нийт зардал |
|--|------------------|-------------|------------|-----------------|-------------|
| Хатуу хог хаягдлыг Дүүрэгтэй байгуулсан гэрээний дагуу зайлуулах         | Төслийн талбай   | ш           | 12         | 160,000         | 1,920,000   |
| Хатуу хог хаягдлын битүүмжлэл бүхий ангилан ялгах хогийн сав суурилуулах |                  | удаа        | 4          | 200,000         | 800,000     |
| <b>Нийт</b>  | <b>2,720,000</b> |             |            |                 |             |

Биелэлт:

1. Манай компани нь НД-н Тээвэрлэлт, үйлчилгээний төвтэй байнгын гэрээтэй ажиллаж ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зохих журмын дагуу хадгалан зайлуулж байна. Хог тээвэрлэлтийн төлбөр тооцоог цаг тухайд төлж байсан болно. /холбогдох гэрээ, баримтыг хавсаргав./
2. Аялал жуулчлалын бааз төслийн ахуйн хог хаягдлыг битүүмжлэл бүхий саванд хадгалж хог тээврийн машинд ачуулж зайлуулж байна. Бид цаашдаа ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгах сав бэлтгэхээр ажиллаж байна. Ахуйн гаралтай цаас, ундааны сав зэрэг хаягдал, гарах бөгөөд дээрх ангилалаар ангилан хаях 4-5 савыг бэлтгэх болно.



Зураг.19. Төрөлжүүлсэн хогийн савны зургууд

## 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

2022 онд бид ус, агаар, хөрс гэсэн 3 орчинд нийт 900,420 төгрөгийн төсөвтэй орчны хяналт шинжилгээ явуулахаар батлуулан ажилласан болно.

### Агаарын шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 10-р сарын 12-ны өдөр байгаль орчны Энвишнгрин” компанийн мэргэжилтнүүд орчны агаарын бохирдлын хэмжилт судалгааг Япон улсад үйлдвэрлэгдсэн агаар дахь CO<sub>2</sub>-н хэмжээг ppm-р тодорхойлогч GCH-2018 багажийг ашиглан хийв.

Агаарын тоосжилтын хэмжилтийг төсөл хэрэгжиж буй талбай дотор авав. PM10 –н агууламж 12 мг/м<sup>3</sup>, PM2.5 –н агууламж 5 мг/м<sup>3</sup> утгатай гарч байна. Хэмжилтийг нийт 50 секундын хугацаанд хийсэн бөгөөд энэ хэмжилтын хугацаагаар жиших стандарт байхгүй юм. Агаарын чанарын стандарт –MNS 4585:2016-нд 24 цагийн хэмжилтийн стандарт PM10 100 мг/м<sup>3</sup>, PM2.5 50 мг/м<sup>3</sup> гэж заасан бөгөөд эдгээр утгаас бага гарч байв. Энэхүү утга нь тухай агшины утга байх юм. Хэмжилтийн явцад орчны температур -16<sup>0</sup>C, агаарын чийгшил 20%, CO<sub>2</sub>-н агууламж 532 ppm буюу 1.16 мг/м<sup>3</sup> байв.

Мөн Энвишнгрин ХХК-ны зүгээс дуу шуугианы бохирдлын судалгааг хийхдээ гаднах талбайд Япон улсад үйлдвэрлэсэн SEM, DT820 маркийн дуу шуугиан хэмжигч багажаар хэмжилтийг 3-5 удаа хийж үр дүнг дундажлан тооцоолов. /Зураг.20, хүснэгт.5./



Зураг.20.Төслийн хашаан доторх агаарын тоосжилт болон дуу шуугианы хэмжилт

Хүснэгт.5. Ажлын байрны бичил цаг уурын үзүүлэлтүүд

| № | Хэмжилт хийсэн газар | Дууны түвшиний доод утга, дБ | Дууны түвшиний дунд утга, дБ | Дууны түвшиний дээд утга, дБ |
|---|----------------------|------------------------------|------------------------------|------------------------------|
| 1 | Төслийн талбай дотор | 45.8                         | 50.8                         | 54.3                         |

Тус судалгааны үр дүнгээс харахад гаднах талбайд үүсгэх дуу чимээний дээд утга нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давж гарсан тохиолдол үгүй байна.



Харин бусад хэмжсэн цэгүүдийн утга зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй боловч үйлчлэлийн хугацаа удаан байх тохиолдолд хүн болон тухайн орчинд дуу, чимээний үргэлжилсэн бохирдлыг үүсгэх юм.

Мөн 2022 оны 4-р сарын 07-нд Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газраар тухайн үед ашиглаж байсан уурын зууханд хэмжилт хийлгэсэн бөгөөд МУ-н стандарт MNS 5043:2016-с давсан үр дүн гараагүй болно.

### Хөрсний шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 10-р сарын 12-нд төслийн хашаан доторх цэгээс дээж авч магадлан итгэмжлэгдсэн “Инженер Геодези” ХХК-ний хөрсний шинжилгээний лабораторит хүнд элементийн шинжилгээг хийлгэсэн болно. /Үр дүнг хавсралтаар оруулав./

Хүснэгт.6. Хөрсний шинжилгээний дүн

| №  | Лаб №   | Дээжний нэр | Гүн см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм |             |                  |          |            |            |
|--|---------|-------------|--------|---|-------------|------------------|----------|------------|------------|
|  |         |             |        | Ni /Никель /                              | Cd /Кадми / | Pb //Хар тугалга | Cu /Зэс/ | Zn /Цайр / | Cr /Хром / |
| 1  | 22/8383 | X-1         | -      | 36.5                                      | ND          | 6.63             | 13.6     | 72.8       | 17.2       |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/                        |         |             |        | 150,0                                     | 3,0         | 100,0            | 100,0    | 300,0      | 150,0      |
| Хортой агууламж /MNS 5850:2019/                        |         |             |        | 1000,0                                    | 10,0        | 500,0            | 500,0    | 600,0      | 400,0      |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/                       |         |             |        | 1800,0                                    | 20,0        | 1200,0           | 1000,0   | 100,0      | 1500,0     |
| <b>Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт</b> |         |             |        | <b>/MNS5850:2019/</b>                     |             |                  |          |            |            |

Тус шинжилгээний дүнгүүдээс харахад хөрсөн дэх хүнд элементийн агууламж нь Монгол улсын стандарт “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”, MNS 5850: 2019 харьцуулан үзэхэд стандартаас бага, утгатай байна.



Зураг.11.Төслийн талбайгаас хөрсний дээж авч буй байдал, 2022-10-12

Мөн 2022 оны 7-р сарын 04-нд Нийслэлийн Налайх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэсийн Нян болон химийн хор судлалын хяналтын лабораторит хөрсний дээж өгч нянгийн шинжилгээ хийлгэсэн бөгөөд стандартаас даваагүй болно.

### **Газар доорх усны шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн талбайд байрлах 1 гүний худгийн уснаас дээж авч Нийслэлийн МХГ-н итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн болно. Дээжийг 2019 оны 3-р сарын 18-нд авч шинжлүүлэв. Гүний худгийн шинжилгээний дүнгүүдээс харвал Монгол улсын стандарт "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ", MNS 0900 – 2018 давсан утга илрээгүй болно.

## 7. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОМТ-д тусгагдсан ажил:

| № | Төлөвлөсөн арга   | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь          | Хариуцсан албан тушаалтан   |
|---|---|-------------------------|------------------------------|---|
| 1 | Байгууллагын удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг тайлагнах (ISO 14001, 2004).   |                         |                              | Компаний удирдлага, орон нутгийн иргэд, БО-ны мэргэжилтэн, орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллага |
| 2 | Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдолог нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх; | Дотоод зардал           | Төслийн үйл ажиллагааны турш |   |
| 3 | Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дүрсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх                           | Нэмэлт зардалд тусгах   | Тухай бүрт нь                | “Гюудонхаус” ХХК  |
| 4 | Компанийн зүгээс гэрээт байгууллагуудад тавих байгаль орчны хяналтыг баталгаажуулж, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хамгаалах, гал түймэр, ослын үед дагаж мөрдөх журмын талаар гэрээнд нарийвчлан тусгах   | 1 000 000               | Төслийн үйл ажиллагааны турш | Компаний удирдлага, гэрээт байгууллагууд  |

Энэхүү төлөвлөгөөний хүрээнд дараахь хэд хэдэн ажлуудыг хийгдсэн байна.

Үүнд:

- Уламжлалт 7 хоног бүрийн техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалт хийгдэж байна. 2018 оноос Олон Улсын Чанарын Удирдлагын ISO 9001:2008 стандартыг нэвтрүүлж дотоод хяналт, сайжруулалтыг тогтмол хийх болсоны нэг нь энэхүү техникийн үзлэг шалгалт юм.
- Галын түймэртэй тэмцэх чиглэлээр онцгой анхааран ажиллаж Нийслэлийн НД-н Онцгой байдлын газраас холбогдох галын дүгнэлтийг авсан болно.
- 2022 оны БОМТ-н төлөвлөгөөг байгаль орчны үнэлгээний “Энвишнгрин” ХХК-р хийж гүйцэтгүүлэн БОАЖЯ-р батлуулсан болно.
- Хөдөлмөр аюулгүй байдлын болон байгаль орчны чиглэлээр 2022 оны 6-р сард бүх ажилчдаа сургалтанд хамруулсан.
- Нийслэлийн НД-н 6-р хороотой Тохижилт, хог цэвэрлэгээний хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулан ажиллаж байна.

## **8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

БОАЖЯ-аас батласан 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлуудыг 5 хэсэгт хуваан тайланд дэлгэрэнгүй тусгаж, дараах дүгнэлтүүдийг хийж байна.

### **ДҮГНЭЛТ**

БОАЖЯ-аас батласан 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийсэн ажлуудыг 5 хэсэгт хуваан тайланд дэлгэрэнгүй тусгаж, дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хүрээнд агаар, ус, хөрс гэсэн байгалийн объект тус бүрээр хамгаалах, нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж гүйцэтгэлээр нийт 25 гаруй сая төгрөгийг зарцуулсан байна. /цахилгаан халаалтын системийг оролцуулаад/
2. Байгаль хамгаалах төлөвлөгөөнд нэмэлтээр нийгмийн хариуцлага, ажилчдын эрүүл, ахуй, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлд олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
3. Хөдөлмөр, аюулгүй байдлын чиглэлээр 2022 оны 3-р сард бүх ажилчдаа сургалтанд хамруулсан болно.
4. Төслийн талбайд хийсэн байгаль орчны хэмжилт, дээж авсан агаар, ус хөрс, шинжилгээний дүнгүүдээс үзвэл стандартаас давсан утга илрээгүй болно.

Цаашид компанийн зүгээс 2023 оны БОМ-ийг төлөвлөхдөө аялал жуулчлалын төслийн БОННУ-ний тайлан, бусад холбогдох журам, стандарт болон дүүрэг болон Нийслэлийн БОГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-с өгсөн зөвлөмж зэрэгтэй уялдуулан гүйцэтгэх болно.


## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

1. Шинжилгээний дүн –Хөрсний элемент, 2022
2. Хөрсний нянгийн шинжилгээний дүнгийн хуулбар
3. Агаарын шинжилгээний дүнгийн хуулбар
4. Усны шинжилгээний дүнгийн хуулбар
5. Нийслэлийн Налайх дүүрэгтэй хийсэн хог хаягдлын гэрээний хуулбар
6. 2022 оны ус ашиглах дүгнэлтийн хуулбар
7. Ус ашиглах гэрээний хуулбар
8. Ус ашиглах эрхийн гэрчилгээний хуулбар
9. 2022 оны бохир усны дүгнэлтийн хуулбар
10. Бохир ус соруулах гэрээ
11. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн хуулбар
12. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн актын хуулбар

### Ашигласан материалын жагсаалт

- БОАЖЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тоот тушаал “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
- Амралтын газрын талбайд хийсэн хээрийн судалгааны материал /2022 оны 3, 11-р сар/
- Шинжилгээний дүнгүүд

Хавсралт-1



ХӨРС СУДЛАЛЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК

Утас/Факс 77278899, 77288899  
E-mail: soil\_lab@geo-mongol.mn

Дугаар: 22/3763

Дээж авсан огноо: 2022 он 10 сарын 14

Шинжилгээ хийсэн огноо: 2022 он 10 сарын 17-18

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, НД, 6-р хороо, Горхи-Тэрэлж БЦГ, “Гюудонхаус” ХХК, АЖБааз төсөл

Координат: 47°49'53.7" 107°23'40.4"

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Энвишнтрийн” ХХК

Харилцах утас: 88830119, 99998517

Хөрсний хүнд металл

| №   | Лаб №   | Дээжний нэр | Гүн, см | Хүнд металл мг/кг |            |                  |          |           |           |
|---|---------|-------------|---------|-------------------|------------|------------------|----------|-----------|-----------|
|   |         |             |         | Ni /Никель/       | Cd /Кадми/ | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1   | 22/8383 | X-1         | -       | 36.5              | ND         | 6.63             | 13.6     | 72.8      | 17.2      |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/                 |         |             |         | 150,0             | 3,0        | 100,0            | 100,0    | 300,0     | 150,0     |
| Хортой агууламж /MNS 5850:2019/                 |         |             |         | 1000,0            | 10,0       | 500,0            | 500,0    | 600,0     | 400,0     |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/                |         |             |         | 1800,0            | 20,0       | 1200,0           | 1000,0   | 1000,0    | 1500,0    |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт |         |             |         | /MNS 5850:2019/   |            |                  |          |           |           |

\*ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний харну нь тухайн цэгийн дээжснд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS ISO 11466:2007)

Лабораторын эрхлэгч:

Л.Цагаандархи /MS.c/


Задлан шинжээч:

О.Дагвийжалам /MS.c/ - z

Хавсралт-2

7/4/22, 1:39 PM

GASI-LIMS



МХЕГ-ын Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний лавлагаа лабораторийн  
Ерөнхий захирлын 2018 оны 05 сарын 09-ний өдрийн А/20 дугаар  
тушаалын хавсралт  
Маягт 01-65

НАЛАЙХ ДҮҮРЭГ ДЭХ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН  
ЛАБОРАТОРИ  
Улаанбаатар хот, Налайх дүүрэг, Дамдины гудамж  
Утас: 70233301

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН  
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар Registration number: 22-132

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр: Гюудон хаус ХХК  
The name of customer's request for analysis

Байцаагчийн нэр The name of inspector: У.Гантуяа

Дэд лабораторийн нэр Name of the sub laboratory: Нян судлалын хяналтын лаборатори; Хими, хор судлалын хяналтын лаборатори

| Дээжийн тодорхойлолт Sample description |  |   |   |  |   |
|---|--|---|---|--|---|
| Дээжийн дугаар Sample number            | Дээжийн нэр Name of sample                     | Цувралын дугаар Batch number                                | Үйлдвэрлэсэн улс The country of original manufacturer | Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа Date of expiry | Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample |
| 321                                     | Хорс   |   | Монгол Улс  | Тодорхойгүй                                    | 500.0 г                                   |
| Хүлээн авсан огноо Date of receipt      |  | Шинжилгээ дууссан огноо Date of test completion             |   | Хэвлэсэн огноо Date of issue of the report     |   |
| 2022 он 06 сар 24 одор                  |  | 2022 он 07 сар 04 одор                                      |   | 2022 он 07 сар 04 одор                         |   |
| Дээжийн дугаар Sample number            | Шинжилгээний аргын стандарт Method of analysis | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter, unit | Шаардлага Test specification, unit                    | Шинжилгээний дүн Test results                  |   |
| 321                                     | MNS 6341:2012                                  | ББЕТ  | -   | 2.0*10 <sup>6</sup>                            |   |
|   | MNS 6341:2012                                  | Эмгэгтөрөгч нян   | -   | 1г-д илрээгүй                                  |   |
|   | MNS 6341:2012                                  | Колититр  | -   | 0.1-ээс их                                     |   |
|   | MNS ISO 7890:3:2001                            | Нитрат  | 130.0, мг/л   | 2.28   |   |
|   | MNS ISO 10390:2001                             | pH  | -   | 8.47   |   |
|   | MNS 6271:2011                                  | Сульфат   | 160.0, мг/л   | 13.90  |   |
|   | MNS 4431:2005                                  | Нитрит  | -, мг/л   | 0.10   |   |
|   | MNS 3675:1984                                  | Органик нүүрстөрөгч   | -, %  | 2.06   |   |
| MNS 3675:1984                           | Ялзмаг   | -, %  | 3.55  |  |   |

Санал тайлбар:

Opinions and interpretation

БАТАЛСАН: ЧАНАРЫН МЕНЕЖЕР:

Approved by



/Х.АЛТАНЧИМЭГ/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна.  
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

Хавсралт-3



Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх  
газрын даргын 2021 оны 10 дугаар  
сарын 15-ны өдрийн А/93 дугаар  
тушаалын хавсралт

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
Арцатын ам Наадамчдын гудам 1200  
тоот.  
Утас 11-318551

ХЭМЖИЛТИЙН ДҮНГИЙН ХУУДАС

Дугаар ЗХ03/16

Он сар өдөр: 2022.04.07

Эзэмшигчийн нэр: “ГЮУДОН ХАУС” ХХК

Хэмжилтийн төрөл: Зуухны хэмжилт

Хэмжилт хийсэн газрын нэр, хаяг: Налайх дүүрэг

| Үзүүлэлт Агууламж | NO <sub>x</sub><br>мг/м <sup>3</sup> | SO <sub>2</sub><br>мг/м <sup>3</sup> | CO<br>мг/м <sup>3</sup> | TSP<br>мг/м <sup>3</sup> |
|-------------------|--------------------------------------|--------------------------------------|-------------------------|--------------------------|
| Багануур          | 277                                  | 412                                  | 1257                    | 544                      |
| MNS 5043:2016     | 450                                  | 800                                  | 5000                    | 600                      |

